

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317

Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батсайхан
Утас: 70453799

Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

МАЛЧИН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ш.БАТТУЛГА ТАНАА

2023.02.24 № УВА-2023/64/ТА-СЛА-ТШЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын дарга 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200123

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,778,840.00 | 127,398,506.00 |
| 33 | АВЛАГА | 800,000.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 800,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 800,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 978,840.00 | 127,398,506.00 |
| 354 | Хангамжийн материал | 978,840.00 | 41,403,840.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 91,500.00 | 91,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 887,340.00 | 41,312,340.00 |
| 35600 | Мал амьтад | 00.00 | 85,994,666.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,327,978,264.13 | 1,421,020,746.41 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,327,978,264.13 | 1,421,020,746.41 |
| 392 | Биет хөрөнгө | 1,276,703,764.13 | 1,358,807,846.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,302,875,911.00 | 1,444,220,961.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -265,110,852.64 | -366,012,952.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 78,094,800.00 | 126,393,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -26,561,855.32 | -45,471,266.51 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 60,489,883.00 | 99,682,351.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -35,046,728.33 | -41,101,172.59 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 73,694,526.00 | 74,050,366.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -44,544,345.94 | -43,306,558.71 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 92,565,484.00 | 92,565,484.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -19,154,467.71 | -37,667,564.55 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 40,434,140.00 | 50,597,490.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,087,559.93 | -16,097,921.63 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 29,980,000.00 | 20,880,000.00 |
| 39217 | Ном | 74,830.00 | 74,830.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 51,274,500.00 | 62,212,900.00 |
| 39301 | Програм хангамж | 2,355,000.00 | 2,355,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,942,500.00 | -2,092,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,862,000.00 | 61,950,400.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,329,757,104.13 | 1,548,419,252.41 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 800,000.00 | 00.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 800,000.00 | 00.00 |
| 413 | Өглөг | 800,000.00 | 00.00 |
| 4136 | Бусад өглөг | 800,000.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 800,000.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,328,957,104.13 | 1,548,419,252.41 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,328,957,104.13 | 1,548,419,252.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 458,478,316.17 | 458,478,316.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 458,478,316.17 | 458,478,316.17 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 282,124,294.55 | 501,586,442.83 |

| | | | |
|----------|--|--------------------------------|--------------------------------|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 282,124,294.55 | 282,124,294.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 219,462,148.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 588,354,493.41 | 588,354,493.41 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,329,757,104.13</u> | <u>1,548,419,252.41</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 586,143,230.00 | 839,129,334.40 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 71,937,960.00 | 366,617,134.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 71,937,960.00 | 366,617,134.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 71,937,960.00 | 366,617,134.40 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 552,960.00 | 176,100.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 71,385,000.00 | 366,441,034.40 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 514,205,270.00 | 472,512,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 145,239,170.00 | 2,580,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 12,057,250.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 130,000,000.00 | 2,580,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,381,920.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 800,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 368,966,100.00 | 469,932,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 368,966,100.00 | 469,932,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 525,483,104.03 | 610,567,186.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 525,483,104.03 | 610,567,186.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 510,591,902.64 | 571,136,733.92 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 246,710,529.15 | 246,507,055.14 |
| 210101 | Үндсэн цалин | 212,959,986.15 | 192,387,626.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 29,813,580.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 4,481,838.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,750,543.00 | 19,824,011.14 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,420,832.00 | 30,974,347.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,516,401.54 | 21,007,841.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,495,329.40 | 2,491,626.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,982,823.35 | 1,988,261.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 502,461.75 | 503,365.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,923,815.96 | 4,983,253.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,050,233.46 | 27,531,819.36 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,589,926.00 | 4,897,182.72 |
| 210302 | Түлш, халаалт | 21,328,307.46 | 22,484,636.64 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 132,000.00 | 150,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,193,923.00 | 40,824,220.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,785,250.00 | 5,420,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,568,727.00 | 26,736,870.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,540,000.00 | 3,900,600.00 |

| | | | |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 166,600.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,133,346.00 | 4,766,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 00.00 | 350,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 350,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,720,200.00 | 10,780,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,720,200.00 | 10,780,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,065,000.00 | 7,718,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,065,000.00 | 7,718,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,582,007.00 | 5,887,326.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 874,723.00 | 4,100,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 170,000.00 | 113,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 277,784.00 | 80,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 688,500.00 | 736,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 239,000.00 | 568,002.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 172,849,178.03 | 200,563,766.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,410,450.00 | 33,660,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,390,000.00 | 2,898,920.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 145,048,728.03 | 164,003,886.12 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14,891,201.39 | 39,430,452.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,482,400.00 | 32,307,340.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,400.00 | 12,553,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 15,974,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 829,000.00 | 3,779,840.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,408,801.39 | 7,123,112.20 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,408,801.39 | 7,123,112.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 60,660,125.97 | 228,562,148.28 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 64,972,400.00 | 9,100,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 64,972,400.00 | 9,100,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -64,972,400.00 | -9,100,000.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -4,312,274.03 | 219,462,148.28 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 514,758,230.00 | 472,688,300.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 552,960.00 | 176,100.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 552,960.00 | 176,100.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 552,960.00 | 176,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 552,960.00 | 176,100.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 514,205,270.00 | 472,512,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 145,239,170.00 | 2,580,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 12,057,250.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 130,000,000.00 | 2,580,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,381,920.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 800,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 368,966,100.00 | 469,932,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 368,966,100.00 | 469,932,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 384,758,230.00 | 472,688,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 384,758,230.00 | 472,688,300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 369,067,028.61 | 433,257,847.80 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 246,710,529.15 | 246,507,055.14 |
| 210101 | Үндсэн цалин | 212,959,986.15 | 192,387,626.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 29,813,580.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 4,481,838.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,750,543.00 | 19,824,011.14 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,420,832.00 | 30,974,347.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,516,401.54 | 21,007,841.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,495,329.40 | 2,491,626.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,982,823.35 | 1,988,261.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 502,461.75 | 503,365.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,923,815.96 | 4,983,253.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,050,233.46 | 27,531,819.36 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,589,926.00 | 4,897,182.72 |
| 210302 | Түлш, халаалт | 21,328,307.46 | 22,484,636.64 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 132,000.00 | 150,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,715,377.00 | 40,909,220.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,785,250.00 | 5,420,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,568,727.00 | 26,736,870.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,540,000.00 | 3,900,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 166,600.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 654,800.00 | 4,851,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 372,400.00 | 350,000.00 |

| | | | |
|-------------|---|-------------------------------|----------------------|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 372,400.00 | 350,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,720,200.00 | 36,820,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 26,100,000.00 |
| 210602 | Тавилга | 2,000,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,720,200.00 | 10,720,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,065,000.00 | 7,718,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,065,000.00 | 7,718,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,582,007.00 | 5,887,326.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 874,723.00 | 4,100,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 170,000.00 | 113,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 277,784.00 | 80,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 688,500.00 | 736,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 239,000.00 | 568,002.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,430,450.00 | 36,559,880.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,040,450.00 | 33,660,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,390,000.00 | 2,898,920.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,691,201.39 | 39,430,452.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,482,400.00 | 32,307,340.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,400.00 | 12,553,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 15,974,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 829,000.00 | 3,779,840.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,208,801.39 | 7,123,112.20 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,208,801.39 | 7,123,112.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>130,000,000.00</u> | <u>00.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 130,000,000.00 | 00.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 130,000,000.00 | 00.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 130,000,000.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 130,000,000.00 | 00.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-130,000,000.00</u> | <u>00.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-----------------------|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 387,333,182.17 | 2,118,704.76 | 194,552,318.65 | 584,004,205.58 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 387,333,182.17 | 2,118,704.76 | 194,552,318.65 | 584,004,205.58 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -13,375,987.09 | -13,375,987.09 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 458,478,316.17 | 588,354,493.41 | 282,124,294.55 | 1,328,957,104.13 |
| D01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 458,478,316.17 | 588,354,493.41 | 282,124,294.55 | 1,328,957,104.13 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 458,478,316.17 | 588,354,493.41 | 282,124,294.55 | 1,328,957,104.13 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 219,462,148.28 | 219,462,148.28 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 458,478,316.17 | 588,354,493.41 | 501,586,442.83 | 1,548,419,252.41 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|-------------|--|----------------|----------------|---------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 469,932,200.00 | 462,985,187.80 | 6,947,012.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 469,932,200.00 | 462,985,187.80 | 6,947,012.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 437,571,700.00 | 430,677,847.80 | 6,893,852.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 249,752,000.00 | 246,507,055.14 | 3,244,944.86 |
| 210101 | Үндсэн цалин | 229,592,000.00 | 192,387,626.00 | 37,204,374.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 29,813,580.00 | 29,813,580.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 4,481,838.00 | -4,481,838.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,160,000.00 | 19,824,011.14 | 335,988.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,985,000.00 | 30,974,347.30 | 1,010,652.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,749,700.00 | 21,007,841.00 | 741,859.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,558,800.00 | 2,491,626.62 | 67,173.38 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,047,100.00 | 1,988,261.25 | 58,838.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 511,800.00 | 503,365.37 | 8,434.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,117,600.00 | 4,983,253.06 | 134,346.94 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,023,200.00 | 27,531,819.36 | 491,380.64 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,098,600.00 | 4,897,182.72 | 201,417.28 |
| 210302 | Түлш, халаалт | 22,744,600.00 | 22,484,636.64 | 259,963.36 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 180,000.00 | 150,000.00 | 30,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 40,643,000.00 | 39,629,220.00 | 1,013,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,344,800.00 | 5,420,050.00 | 924,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,459,100.00 | 25,456,870.00 | 1,002,230.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,893,200.00 | 3,900,600.00 | -7,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 00.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,745,900.00 | 4,851,700.00 | -1,105,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 372,400.00 | 350,000.00 | 22,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 372,400.00 | 350,000.00 | 22,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,824,900.00 | 7,718,000.00 | 106,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,824,900.00 | 7,718,000.00 | 106,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,434,500.00 | 5,887,326.00 | 547,174.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,160,000.00 | 4,100,000.00 | 60,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 332,000.00 | 113,850.00 | 218,150.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 263,000.00 | 80,974.00 | 182,026.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 00.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 738,500.00 | 736,500.00 | 2,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 609,000.00 | 568,002.00 | 40,998.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 357,165,000.00 | 352,598,880.00 | 456,620.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,800,000.00 | 32,360,960.00 | 439,040.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,916,500.00 | 2,898,920.00 | 17,580.00 |

| | | | | |
|---------|--|----------------|----------------|--------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32360500.00 | 32307340.00 | 53,160.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,360,500.00 | 32,307,340.00 | 53,160.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,833,000.00 | 3,779,840.00 | 53,160.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 469,932,200.00 | 462,809,087.80 | 7,123,112.20 |
| | Орон нутгийн төсвөөс | 469,932,200.00 | 462,809,087.80 | 7,123,112.20 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 176,100.00 | 176,100.00 | 0.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 176,100.00 | 176,100.00 | 0.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|--------|---|------------|---------------------|-------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 2,580,000.00 | -2580000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,580,000.00 | -2580000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,580,000.00 | -2580000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 1,280,000.00 | -1280000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,280,000.00 | -1280000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1300000.00 | -1300000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,300,000.00 | -1300000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 2580000.00 | -2580000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 2,580,000.00 | -2580000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,580,000.00 | -2580000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 218,662.1 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|--------------------|------------------|--|
| | | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
| Б | 1 | 2 | 3=2-1 | |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 | |
| Авлага | 800.0 | 0.0 | -800.0 | |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 | |
| Бараа материал | 978.8 | 127,398.5 | 126,419.7 | |
| Үндсэн хөрөнгө | 1,327,978.3 | 1,421,020.7 | 93,042.4 | |
| Нийт хөрөнгө | 1,329,757.1 | 1,548,419.2 | 218,662.1 | |
| Өр төлбөр | 800.0 | 0.0 | -800.0 | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 458,478.3 | 458,478.3 | 0.0 | |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,329,757.1 | 1,548,419.2 | 218,662.1 | |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны 800.0 мянган төгрөгийн авлага буурснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “баяд үүлдрийн” үржлийн аж ахуй байгуулсантай холбоотойгоор 85,994.7 мянган төгрөгийн хуц, 37,400.0 сая төгрөгийн өвөлжөөг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 70,005.4 мянган төгрөгийн барилга байгууламж, 48,299.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 46,614.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8,500.0 сая төгрөгийн тавилга эд хогшил, 81,349.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны 800.0 мянган төгрөгийн төлж барагдуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 373,253.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 96,678.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 469,932.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 469,932.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 469,932.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 462,985.2 сая төгрөг буюу 98.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | /мянган төгрөгөөр/ | | | |
|-----|------------------------|--------------------|-----------|---------|---------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Орон нутгийн удирдлага | 469,932.2 | 462,985.2 | 1,301.9 | 98.6% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 2.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,280.0 мянга, Бараа үйлчилгээний бусад зардал 1,300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Засаг даргын тамгын газрын дарга Ш.Баттулгад танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Засаг даргын тамгын газрын хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байгаа тул 2021 оны нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, төлөвлөлтийн материаллаг байдлын түвшинг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 612,122.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 612.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн 80 хувиар буюу 489.7 мянган төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийг арвилан хэмнэж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 123, хугацаа хоцроож 28 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малчин сумын Засаг даргын тамгын газрын дансанд 85,994.7 мянган төгрөгийн хурган хуц, 37,400.0 сая төгрөгийн өвөлжөөг бүртгэлд тусгасан асуудлыг Төрийн аудитын байгууллагын 2023 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсан “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгаж, шийдвэрлэхээр болов.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/С.БАТСАЙХАН/

2023 оны 02 сарын 10-ны өдөр